



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/26

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйл, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хэнтий аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.17 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цэргийн штабын албан хэрэгцээнд цэргийн бүртгэлийн цахим системийг нэвтрүүлэхэд шаардагдах 3.300.000 /гурван сая, гурван зуун мянган/ төгрөгийг зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх үйл ажиллагааны зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын цэргийн бэлтгэл сургууль, цугларалт, зориулалтын бараа үйлчилгээний бусад зардлаас гаргахыг нягтлан бодогч /Э.Ариунтунгалаг/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.ГАНБААТАР